



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/04

Булган

Мод тээвэрлэхийг журамлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.м, 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Агт, Хангал, Сэлэнгэ, Бугат, Орхон, Хутаг-Өндөр, Тэшиг сумын нутаг дэвсгэрт ойн нөхөрлөл, иргэний нэрийн дор түлшний модыг ихээр бэлтгэн Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хот руу тээвэрлэх явдал нэмэгдэж байгаатай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/153 дугаар тушаалаар баталсан "Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих тухай журам"-ыг хэрэгжүүлэх, орон нутгийн иргэдийн өвөлжилтийн бэлтгэл түлшний модны хэрэгцээг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрээс Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг руу түлшний мод болон нарс мод тээвэрлэхийг 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр хугацаагаар хориглосугай.
2. Захирамжийг орон нутагтаа сурталчилан хэрэгжүүлэхийг сум дундын Ойн ангийн дарга болон холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Батболд/, Цагдаагийн газар /хурандаа Н.Батбаяр/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т тус тус үүрэг болгосугай.



З.БАТЗОРИГ

20200007